



**“ГУТАЛ” ХУВЬЦААТ
КОМПАНИ**

Улаанбаатар-17043, ХУД, 2-р хороо
Чингисийн өргөн чөлөө, “Гутал” ХК

Утас: 976 -11 - 341678

Факс: 976 -11- 343267

Вэб сайт: www.gutalco.mn .

Э-шуудан: gutal.zahirгаа@gmail.com

2025. 02.11

№ 5/25-10

танай _____

-ны _____

-т

**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН
БИРЖ-д**

ТУЗ-н тогтоол хүргүүлэх тухай

“Гутал” ХК /РД:2075423/-н ногдол ашиг
хуваарилах тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоол,
хурлын тэмдэглэл хүргүүлж байна.

Хүлээн авна уу.

Хуудас: 5

Хүндэтгэсэн,
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Ц.ТӨМӨР





**“ГУТАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2025 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46, 47 дугаар зүйлийн, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь хэсэг, 80 дугаар зүйлийн 80.6 дахь хэсэг, “Гутал” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.31.8 дахь хэсэг, 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн “Гутал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Гутал” ХК нь 2024 оны цэвэр ашиг, мөн үеийн санхүүгийн нөхцөл байдал, эрсдэлийн зохистой харьцаа зэргийг үндэслэн нэгж хувьцаанд 2470 /хоёр мянга дөрвөн зуун далан/ төгрөгтэй тэнцэх ногдол ашиг хуваарилсугай.
2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг 2025 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдрөөр буюу 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөр тогтоосугай.
3. 2024 оны ногдол ашгийг 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн холбогдох хууль, журмын дагуу олгохыг гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА**



Б.БАТБИЛЭГ



“ГУТАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улаанбаатар-17043
ХУД, 2-р хороо
Чингисийн өргөн чөлөө
“Гутал” ХК

Утас: 976 -11 - 342637
Факс: 976 -11- 343267
Вэб сайт: www.gutalco.mn
Э-шуудан: gutal.company@gmail.com

Огноо 2025. 02. 11

Дугаар 01

Улаанбаатар хот

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурал 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 11 цагт компанийн ТУЗ-ийн өрөөнд эхэллээ. Хурал ТУЗ-ийн дараах гишүүд оролцлоо.

1. Б.Жаргал – “Гутал” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүн
2. С.Бат-Эрдэнэ – “Гутал” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүн
3. Э.Билгүүн— “Гутал” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүн
4. Б.Батбилэг – “Гутал” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүн
5. Б.Батхишиг – “Гутал” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүн
6. Б.Баттөр – “Гутал” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүн
7. Ч.Цэцэгмаа – “Гутал” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүн
8. Ц.Төмөр – “Гутал” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүн
9. Т.Билэгт – “Гутал” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүн нар тус тус биечлэн оролцохоор ирсэн.

Хурлын ирц:

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 8 гишүүд биечлэн, нэг гишүүн Т.Билэгт итгэмжилсэн төлөөллөөр, нийт 9 гишүүн хуралд оролцож байна. Хурлын ирц 100 хувь.

Хэлэлцэх асуудал:

1. 2024 оны ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр;

ТУЗ-ын дарга Б.Батбилэг хурлыг нээлээ. Хурал 11.00 цагт эхэллээ.

Б.Батбилэг:

Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе! ТУЗ-ын хурлын ирц 100 хувь байгаа тул хурлаа эхлүүлэе. Хэлэлцэх асуудлыг та бүхэнд урьдчилж тараасан байгаа. Хэлэлцэх асуудлын талаар өөр санал байна уу? Байхгүй бол хэлэлцэх асуудлаа батлах уу?

Гишүүд санал нэгтэй хэлэлцэх асуудлаа баталлаа.

Б.Батбилэг:

Ингээд 2024 оны ногдол ашиг хуваарилах тухай асуудлаа хэлэлцье. Ерөнхий Захирал Ц.Төмөр асуудлаа танилцуулна уу.

Ц.Төмөр:

Компанийн нийт гаргасан 1,618,684 ширхэг энгийн хувьцаанаас саналын эрхгүй 43,674 ширхэг энгийн хувьцааг хасаж 1,575,010 ширхэг хувьцаанд 2024 оны ногдол ашиг хуваарилах саналтай байна. Тайлант үеийн ашиг, алдагдал мөн хуримтлагдсан ашиг нийлээд 3.9 орчим тэрбум төгрөг байна. Иймд ногдол ашиг хуваарилах санал гаргасан.

С.Бат-Эрдэнэ:

Нэгж хувьцаанд хэдэн төгрөгийн ногдол ашиг хуваарилах вэ?

Ц.Төмөр:

Нэгж хувьцаанд 2470 төгрөг олгох саналтай байна. Үүнийг нийт ногдол ашиг хүртэх хувьцааны тоонд тооцож үзэхэд 3.89 орчим тэрбум төгрөг хуваарилахаар байна.

Ч.Цэцэгмаа : Саналыг дэмжиж байна. Компанийн үйл ажиллагааг тогтвортой авч явахад шаардагдах санхүүжилтийг тооцож ногдол ашгийн хэмжээг тогтоосон уу?

Ц.Төмөр:

Үйл ажиллагааны орлогоор шаардлагатай санхүүжилтийг бүрдүүлэх бүрэн боломжтой .

Б.Бат-Эрдэнэ:

Ногдол ашиг авах хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр болон ногдол ашиг олгож эхлэх өдрийг хэдний өдрөөр тогтоох вэ?

Б.Батбилэг:

Миний хувьд ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг 2025 оны 3-р сарын 31-ний өдрөөр буюу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралын нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөртэй дөхөж очино гэж үзэж энэ өдрөөр, компанийн хугацаатай хадгаламжинд байгаа өдрийг тооцож 6 сарын 5-ны өдрөөр тус тус тогтох саналтай байна.

Гишүүд санал нэг байв.

Б.Батбилэг:

Гишүүдэд өөр санал, асуулт байна уу?

Гишүүдээс өөр асуулт, санал гараагүй тул хурал даргалагч шийдвэрийн төслийг гишүүдэд уншиж танилцуулав.

Б.Батбилэг:

Энэ шийдвэрийг батлах уу?

ТУЗ-н гишүүд бүгд санал нэгтэйгээр шийдвэрийн төслийг батлав.

Гишүүд санал нэгтэйгээр Ногдол ашиг хуваарилах тухай тогтоолын төслийн батлав.

ТУЗ-ийн хурал 11 цаг 40 минутанд дуусав.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ТУЗ-ИЙН НАРИЙН

БИЧГИЙН ДАРГА О.МАРАЛ-ЭРДЭНЭ



ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН:

ХУРАЛД ОРОЛЦСОН ТУЗ-ИЙН ГИШҮҮД

Б.БАТБИЛЭГ

Ц.ТӨМӨР

Б.БАТХИШИГ

Б.БАТТӨР



Ч.ЦЭЦЭГМАА

Ч. Цэцэгмаа

Т.БИЛЭГТ

Э.БИЛГҮҮН

С.БАТ-ЭРДЭНЭ

Б.ЖАРГАЛ